



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup> дугаар зүйлийн 12<sup>1.2</sup> дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup> дугаар зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг дараах байдлаар тус тус шинэчлэн баталсугай:

Дарга:

1. Б.Бат Санхүүгийн зохицуулах хорооны даргын зөвлөх

Гишүүн:

2. Н.Мандуул Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга

3. Б.Эрдэнэбат Замын цагдаагийн газрын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

4. М.Мөнхбаяр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Тамгын газрын дарга

5. Э.Ганхүү Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

6. Т.Батзул Монголын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, “Монгол даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал

7. Ж.Батжаргал Монголын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал

8. М.Бизаагундаа Монголын хохирол үнэлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал

2. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 301, 2012 оны 307, 2013 оны 29, 65, 189, 287, 364, 2014 оны 466, 2015 оны 93, 99, 126, 401, 2016 оны 69, 142 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН